



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2022 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 4/08

Мандалговь

“Мэргэжлийн хяналтын газарт Кьеңдаль багаж болон  
Пестицидийн үлдэгдэл тодорхойлох багаж нийлүүлэх”  
тандерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах  
үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Мэргэжлийн хяналтын газарт Кьеңдаль багаж болон Пестицидийн үлдэгдэл тодорхойлох багаж нийлүүлэх” тандерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: М.Батсайхан (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийтлэг үйлчилгээний дарга)

Гишүүд:  
Ц.Эрдэнээ (Иргэний төлөөлөл)  
Э.Буяндэлгэр (Цаг уур орчны шинжилгээний газрын лабораторийн инженер)

О.Шинэжаргал (Аймгийн Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК-ны няглан бодогч)

Нарийн бичиг: М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Үнэлгээний хороо тандер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (М.Батсайхан)-д даалгасугай.

3. Тандер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

И. ДОРЖБАТ

4822150015